



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 1129

Улаанбаатар хот

Коронавируст халдвар (Ковид-19)-аас
сэргийлэх, тархалтыг бууруулах зарим
арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын нийт ажилтны хүүхдүүдэд дархлаа дэмжих бүтээгдэхүүн авах зардалд 2 250 000 (Хоёр сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.
2. Дархлаа дэмжих бүтээгдэхүүн хүлээн авах хүүхдүүдийн нэрсийг нэгдүгээр хавсралтаар, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Дархлаа дэмжих бүтээгдэхүүнд худалдан авахад зарцуулагдах төсвийг Хот төлөвлөлт, судалгааны институтын 2021 оны зардлын үйл ажиллагааны бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүү менежмент хариуцсан орлогч дарга (Б.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГА



Ч.РЭГЗМАА